



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/БТ

Мандалговь

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог байгуулах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд зөв зохистой хүмүүжил олгох, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
Гишүүд:	ГХУСЗ-ийн ажилтан
	Нийгмийн бодлогын хэлтсийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
	Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч
	Цагдаагийн газрын мөрдөн байцаагч
	Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч
	Прокурорын газрын хяналтын прокурор
	Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга
	Аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгчийн туслалцаа
	ШШГА-ны ахлах шийдвэр гүйцэтгэгч
	Эрүүл мэндийн газрын Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
	Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга
	Сайнцагаан сумын Нийгмийн бодлогын ажилтан
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн Бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн
	"Оюуны гэгээ" нийгэмлэгийн тэргүүн

Хоёр. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн зөвлөгөө үйлчилгээ, туслалцаа үзүүлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулж ажиллахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000181